

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Засаглалын бодлого” зорилтын Шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “5.3.7.Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу “Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр”-ийг “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам” -д нийцүүлэн боловсруулав.

Хөтөлбөрийн зорилго нь иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус хэлбэрээр нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан агуулгаар хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд орших бөгөөд энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд: 1/бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, 2/бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлж, тогтсон сувгуудыг бий болгон, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэх, 3/иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулах гэсэн 3 үндсэн зорилтыг дэвшүүллээ.

Хөтөлбөрийг 2018-2023 онд 5 жилийн хугацаанд дараах 2 үе шаттай хэрэгжүүлэхээр төсөлд тусгалаа. Үүнд:

- 1 дүгээр үе шат /2018-2020 он/-нд бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд;
- 2 дугаар үе шат /2021-2022 он/-нд эхний шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны 20 чиглэлээр 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх гол арга зам нь:

- эрх зүйн мэдээлэл
- эрх зүйн сурталчилгаа
- эрх зүйн сургалт
- эрх зүйн туслалцаа
- эрх зүйн судалгаа байх бөгөөд эрх зүйн хөтөчийн тогтолцоог бий болгох, эрх зүйн цахим хөтөч ажиллуулах, эрх зүйн туслалцааны үндэсний

сүлжээтэй болох зэрэг олон шинэ зорилт, арга хэмжээг энэхүү хөтөлбөрийн төсөлд тусгасан болно. Хууль зүйн туслалцааны 2 шатлалтай үйлчилгээг хөгжүүлэх, анхан шатны зөвөлгөө, үйлчилгээг хуульчид, өмгөөлөгчдөөс гадна эрх зүйн хөтөч, клиник сургалтын төвүүдээр үзүүлэх боломжтой болохоор тусгалаа.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яам нэгдсэн удирдлагаар хангах ба эрх зүйн боловсролын агуулгын нэгдсэн байдал, салбар дундын уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих чиг үүрэг бүхий, хууль зүй, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбар, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөлөөс бүрдсэн бүх нийтийн эрх зүйн боловсролын орон тооны бус Үндэсний зөвлөл ажиллахаар хөтөлбөрийн төсөлд тусгасан. Мөн бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаанд бүх шатны төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн идэвхтэй оролцоог хангахаар зааж, төрийн байгууллагуудын үүргийг тусгалаа. Түүнчлэн хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт, хэрэгжих хугацаа, санхүүжилт, хэрэгжилтийг тайлагнах болон хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нөхцөл, журмыг тусгалаа.

Төсөлд дэвшүүлсэн зорилтуудыг хангахын тулд “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хуулийг шинэчлэх ба Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төвийн бүтэц зохион байгуулалтын зарим асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд **нийт 11,257.7 сая** төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоолол гарсан бөгөөд санхүүжилтийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын зээл тусламж, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, хөрөнгө байхаар тооцлоо.

Хөтөлбөрийн үзэл баримтлалыг болон хөтөлбөрийн төслийг нийслэл, 21 аймаг, бүх сум, дүүргийн иргэдийн төлөөлөл 850 гаруй хүнийг оролцуулсан 5 удаагийн хэлэлцүүлгийг Улаанбаатар хот, Хэнтий, Ховд, Өвөрхангай аймгуудад бүсчлэн зохион байгуулж, ирсэн саналуудыг тусгасан ба төслийг боловсруулах шатанд бусад улсын шилдэг туршлага, олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийг судалсан болно.